



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/211

Улаанбаатар хот

Тамхи худалдах зөвшөөрөл
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.9, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 7/64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрнаас 500 метрийн тойргоос гадна байрлан, тамхи худалдах шаардлага ханган үйл ажиллагаа явуулж буй хавсралтад заасан нэр бүхий байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгахыг Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох худалдаа үйлчилгээний байгууллагыг хавсралтаар баталсугай.

3.Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг мөрдөж ажиллахыг холбогдох аж ахуйн нэгжид хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн)-т, 1 дүгээр хорооны Засаг дарга (Н.Нямзав) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалт, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2025 он ажил/захирамж

1225010677